

Улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 7
сарын 01-ны өдрийн 3648 дугаарт бүртгэ
Монгол Улсын Хууль зүйн яам



ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/284

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журам"-ыг нэгдүгээр, "Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилгын загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Л.Баатарчулуун/, хэрэгжүүлж ажиллахыг Зөвшөөрөл, бүртгэлийн газар /С.Хүдэрчулуун/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын 2010 оны А/429 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.БОЛД

000001547

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний
ерөнхий газрын даргын 2016 оны 66
дугаар сарын 10-ны өдрийн 11284
дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭНД МОНГОЛ УЛСАД ХУВИЙН ХЭРГЭЭР
ЗОРЧИХ УРИЛГА ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад гадаадын иргэнийг хувийн хэргээр урих Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид "гадаадын иргэн" гэх)-ий хүсэлтийг хүлээн авч, Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга (цаашид "урилга" гэх) олгох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Урилга нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу гадаадын иргэнд Монгол Улсын виз олгох үндэслэл болно.

1.3. Энэхүү журам нь Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хөндөхгүй.

1.4. Урилгыг иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид "Ерөнхий газар" гэх) олгоно.

Хоёр. Уригч, уригдагч, тэдний эрх, үүрэг

2.1. Уригч гэж Ерөнхий газраас энэ журмын дагуу урилга авахаар хүсэлт гаргаж байгаа 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, тус улсад хууль ёсоор 90 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг, уригдагч гэж уригдахаар хүсэлт гаргагч болон уригчаас өөрт нь илгээсэн урилгыг хилийн чанадад байхдаа хүлээн авсан гадаадын иргэнийг ойлгоно.

2.2. Уригч дараах үүрэг хүлээнэ:

2.2.1. урилга мэдүүлэх хуудсыг үнэн зөв бөглөх;

2.2.2. Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг гаргах;

2.2.3. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэх, уригдагчийг Монгол Улсад байх хугацаанд түүний аюулгүй байдлыг хариуцах, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэн сахиулах;

2.2.4. уригдагчийг Монгол Улсад байх визийн хугацаанд нь буцаах;

2.2.5. хуульд заасан бусад.

2.3. Уригдагч Монгол Улсад байх хугацаандаа дараах үүрэг хүлээнэ:

2.3.1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэх, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэх;

2.3.2. Монгол Улсад байх визийн хугацаанд буцах;

2.3.3. хуульд заасан бусад.

2.4. Дор дурдсан гадаадын иргэн уригдагч байх эрх эдлэхгүй:

2.4.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үндэслэлээр;

2.4.2. Уригдагч гадаадын иргэн нь уригч хувийн урилга олгох хүсэлт гаргахаас өмнө 3 сарын хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан зөрчил гаргаж захиргааны шийтгэл хүлээсэн.

Гурав. Урилга авах хүсэлт гаргах, шийдвэрлэх

3.1. Уригч нь мэдүүлгийн хуудас бөглөн дараах бичиг баримтыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж хүсэлтээ гаргана:

3.1.1. өргөдөл;

3.1.2. иргэний үнэмлэх, Монгол Улсад оршин суух үнэмлэх;

3.1.3. уригдагч гадаадын иргэний гадаад паспорт, паспортыг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар;

3.1.4. уригдагч гадаадын иргэний Монгол Улсад байх хугацаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн талаарх баталгаа;

3.2. Уригч нь урилга хүссэн өргөдөлдөө уригдах гадаадын иргэний Монгол Улсад зорчих шалтгаан, зорилгыг тодорхой зааж, гадаадын иргэнийг тус улсад байх хугацаанд хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, нутаг буцаах талаар дурдана.

3.3. Уригчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авсан мэргэжилтэн дараах мэдээллийг шалган урилга олгох үндэслэлтэй эсэхийг тогтооно:

3.3.1. уригч нь энэ журамд заасан уригч байх эрхтэй эсэх;

3.3.2. уригдагч нь энэ журамд заасан уригдагч байх эрхтэй эсэх;

3.3.3. уригч нь өмнө урьсан гадаадын иргэнээ Монгол Улсад байх визийн хугацаанд нь буцааж байсан эсэх;

3.3.4. уригдагчийн талаар үнэн зөв мэдээлэл өгч байгаа эсэх.

3.4. Шаардлагатай тохиолдолд зарим гадаад орны иргэнд хувийн урилга олгохдоо хууль хяналтын байгууллагаас санал авч шийдвэрлэнэ.

3.5. Урилгыг 30 хүртэл хоногоор олгоно.

3.6. Урилга нь бичигдсэн өдрөөс хойш 90 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

3.7. Урилга олгохоор зөвшөөрсөн тохиолдолд мэдүүлгийн хуудас бөглүүлж, урилгын хураамжийг төлүүлнэ. Урилгыг ажлын 5 өдөрт, яаралтай үйлчилгээг ажлын 3 өдөрт багтаан олгоно.

3.8. Урилгад Ерөнхий газрын даргаас эрх олгогдсон албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

3.9. Уригдагч нь уригчаас илгээсэн урилгыг хүлээн авч Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт холбогдох бичиг баримтын хамт бүрдүүлэн виз авах хүсэлтээ гаргана.

3.10. Ерөнхий газар нь урилгыг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт цахим хэлбэрээр илгээж болно.

3.11. Урилга олгогчоос урилга олгохоос татгалзсан тохиолдолд шалтгааныг тайлбарлах үүрэг хүлээхгүй.

Иргэний харьяалал, шилжилт, нөдөлгөөний
ерөнхий газрын даргын 2016 оны 06
дугаар сарын 10-ны өдрийн 284
дугаар татварын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ
УРИЛГА
INVITATION

Уригдагч / Invitee /

№.....

Овог нэр / Паспортон дээрх нэр / /Surname and given name as in passport/

Иргэний харьяалал /Citizenship/

Паспортын дугаар, хүчинтэй хугацаа / Passport number, date of expiry /

Төрсөн огноо, хүйс, гадаад улс дахь хаяг / Date of Birth and sex, full contact
or residential address in foreign country /

Монгол улсад байх хаяг, утас / Address and telephone in Mongolia /

Монгол улсад байх хугацаа / Duration of stay /

Хамт уригдагч 16 хүртэл насны хүүхэд / Accompanying children under 16 /

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....
- 5.....

Уригчийн / Inviters /

Овог нэр / Surname and given name /

Регистр, паспортын дугаар / Registration or passport number /

Эрхэлсэн ажил, сургууль / Name and address of present employer or school /

Оршин суух, утас / Residential address /

Урилга олгосон байгууллага, газар / Issued by / :

Гарын үсэг, тэмдэг / Signature, stamp / :

Олгосон огноо / Date of issue / :

Урилга олгосон өдрөөс хойш 3 сарын хугацаанд хүчинтэй.

/ Valid for Three months from issued date

САНАМЖ

1. Уригдагч нь зөвшөөрсөн хугацаанд багтан Монгол Улсаас гарч явах үүрэгтэй. Хэрэв уг хугацаанд гарч яваагүй бол холбогдох хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.
2. Уригч нь энэхүү урилгаар хүлээн авсан уригдагчийнхаа орон байр, аюулгүй байдал, эрүүл мэнд болон бусад үр дагаврыг бүрэн хариуцаж, түүнийг баталгаа гаргасан хугацаанд нь буцаах үүрэг хүлээнэ.

NOTES

1. The invitee must leave Mongolia within the permitted period/date specified in the invitation. Should the invitee fail to leave Mongolia within the permitted period/date specified in the invitation, he/she will be subject to accordance with the Law.
2. The inviter shall be fully responsible for accommodation, safety, health and other related issues arising out of this invitee in accordance with this invitation and for invitees return within the guaranteed period.

Санамжтай танилцсан/
/Signature/

/